

БАТЛАВ:

НИЙСЛЭЛИЙН ЗАМ, ТЭЭВРИЙН  
АСУУДАЛ ХАРИУЦСАН ТӨСЛҮҮДИЙН  
УДИРДАГЧ

ЗӨВШӨӨРСӨН:

НИЙСЛЭЛИЙН АВТО ЗАМЫН  
ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ОТГОНСУХ

Б.ИНДРА

АВТО ЗАМЫН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ДААЛГАВАР

Дугаар: ЗД2020/055

Улаанбаатар хот

1.Зураг төсөл боловсруулах үндэслэл	- ХБХГ-ын 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн ГБМЗХ2020/06-006 дугаар архитектур төлөвлөлтийн даалгавар - Нийслэлийн Засаг даргын 2020 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн А/130 дугаар захирамж
2. Байршил	Нисэхийн авто замаас Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын ажилчдын орон сууц хүртэлх авто зам /Хан-Уул дүүрэг, 16 дугаар хороо/
3. Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	Нийслэлийн замын сангийн төсвийн хөрөнгөөр
4.Замын техникийн ангилал, замын зэрэг	Нутаг дэвсгэрийн туслах гудамж зам
5.Газрын бартаалаг, төвөгшил	Трасс/сонголтын үеийн болон замын төсөллөлтийн төвөгшлийг БНБД-ээс харах
6. Замын хучилтын хийц	Хучилтын бүтээцийг тооцоогоор үндэслэнэ
7. Зураг төсөл зохиох үе шат, хугацаа	1 үе шаттай 2020 он
8.Зураг төслийн байгууллага	Авто зам, замын байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөлтэй байгууллага
9.Захиалагч байгууллага	Нийслэлийн Авто замын хөгжлийн газар;
10.Зураг төслийн иж бүрдэл	1. Инженер геодезийн ажлын тайлан 2. Инженер-геологийн судалгааны ажлын тайлан 3. Авто зам, замын байгууламжийн инженерийн нарийвчилсан зураг төсөл 4. Зураг төслийн ажлын магадлалын ерөнхий дүгнэлт 5. Зургийн тайлбар бичиг (ус зайлуулах болон инженерийн байгууламжийн тооцоо, хучилтын тооцоо, ажлын нэр, тоо хэмжээ, холбогдох захирамж, техникийн нөхцөлүүд) 6. Техникийн шаардлага 7. Авто зам, замын байгууламжийн нэгдсэн төсөв
11. Онцгой нөхцөл:	➤ Авто замын зургийг Монгол улсад мөрдөж буй “Авто зам төсөллөх” ЗЗБНБД 22-004-2016, “Авто зам, гүүрийн зураг төсөл, хайгуулын ажлын жишиг үнэ” БД81-

104-02, "Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм" БНБД 30.01.04, "Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн нормаль" БД31.101.04, "Авто замын гүүр ба хоолой төсөллөх" БНБД 32-02-12, Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар" MNS 6056:2009, "Авто зам, замын байгууламж болон инженерийн шугам сүлжээний ажлын төсөвт өртгийг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй төсвийн жишиг нормын дагуу тооцох, магадлалаар оруулан баталгаажуулах, ЗТХ-ийн Сайдын 2018 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 168 дугаар тушаалаар батлагдсан "Авто зам, замын байгууламжийн зураг төсөлд магадлал хийж, дүгнэлт гаргах журам" болон бусад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох норм дүрмүүдийг үндэслэх.

- "Геодези зураг зүйн тухай" хуулийн 6.1.3 дугаар заалт, "Барилга байгууламжийн инженерийн судалгааны нийтлэг үндэслэл" БНБД 11-07-04-ын II хэсэг инженер геодезийн ажил, "Геодезийн ажил" БНБД 3.01.03-88-д тавигдах шаардлагын дагуу зураг төслийг боловсруулах
- Хэмжилт зураглалын ажлыг улсын сүлжээний цэгүүдэд тулгуурлан хийх, геодези, байр зүйн зураглалын ажлын иж бүрэн тайланг батлуулан хүлээлгэн өгөх, зам барих үед геометр хэмжээг хангах хэмжилтийн төсөл-даалгавар боловсруулах. Геодезийн хяналтын инженерээр хянуулж баталгаажуулах
- Улаанбаатар хотын Ерөнхий төлөвлөгөө, Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх Ерөнхий төлөвлөгөөний тодотгол 2030 оны хөгжлийн чиг хандлага, Улаанбаатар хотын хэсэгчилсэн Ерөнхий төлөвлөгөө, гэр хорооллын дахин төлөвлөлтийн ажлын хүрээнд хийгдэх авто зам, орон сууцны хороолол доторх шинээр болон өргөтгөл шинэчлэлт хийгдэж байгаа авто замын зураг төслийн трасстай уялдуулан зураг төслийг боловсруулах
- Инженер геологийн судалгаа хийж, хэсэг бүрт хөрсний геотехникийн үзүүлэлтүүдийг нарийвчлан тогтоон замын байгууламжийн бүтээцийг тооцоогоор оновчтой сонгох. Хөрсний шинж чанараас шалтгаалан замын суурийг оновчтой сонгох.
- Гадаргуугийн ус зайлуулалтыг ус хураах талбайн хэмжээнд тооцоо хийж төлөвлөх, ус зайлуулах байгууламжийг цогцоор нь шийдэх.
- Инженерийн шугам сүлжээний байгууллагуудын техникийн нөхцөлийг тусгах, ажлын зураг боловсруулах, холбогдох байгууллагатай зөвшилцөх, ажлын зургийг батлуулах.
- Авто замын үндсэн элементүүд болох зорчих хэсэг, явган хүний зам, нийтийн тээвэр болон автомашины зогсоол, автомашин, явган хүний гарц, дугуйн зам, ногоон байгууламж, гадаргуугийн усыг зайлуулах байгууламж болон хөндөгдөж буй шугам сүлжээ зэргийг хамруулан ажлын зургийг иж бүрнээр төсөллөх.
- Авто замын төлөвлөлтийг огтлолцож буй болон холбогдож буй бүх талын замын төлөвлөлттэй уялдуулах.
- Авто замын трассад орсон барилга байгууламж, нийтийн эзэмшлийн эд зүйлсийг нарийвчлан гаргаж тайлбар бичигт газар чөлөөлөлтийн талаар тусгайлан оруулах, зургийн шийдлийн дагуу зайлуулах бол тусгах.
- Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчинг бүрдүүлэх зорилгоор зам талбайн болон хөдөлгөөн зохион байгуулалтын арга хэмжээ, тоноглол, замын холбогдох байгууламжуудыг тусгасан байх.
- Уулзвар, хөдөлгөөн зохион байгуулалтыг цогц шийдвэрлэх. Замын


Хөдөлгөөний Удирдлагын төвтэй зөвшилцөх

- Хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган замын дагууд тэмдэг, тэмдэглэгээ, хөдөлгөөн зохицуулалтын тоноглолыг иж бүрэн байдлаар зураг төсөлд тусгах.
- Байр зүйн болон өндрийн хэмжилтийн UTM системд хийх.
- Авто замын гэрэлтүүлгийг төлөвлөлт хийж, хүчин чадлыг тодорхойлсны дараа тухайн зөвлөх нь “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК руу бие даан хандаж /өргөдлийн маягт бөглөх/ техникийн нөхцөл авч /эх үүсвэрийг тодруулах/ ажлын зургийг боловсруулах. Одоо байгаа гэрэлтүүлгийн шонг шилжүүлэх, дэд станцыг шилжүүлэх зэрэг холбогдох асуудлуудыг мөн шийдвэрлэсэн байх
- Авто замын гэрэлтүүлгийг эрчим хүчний хэмнэлттэй, шар тусгалтай чанарын шаардлага хангасан “LED” технологиор шийдвэрлэх
- Зураг төслийг дараах масштабтайгаар боловсруулна. Үүнд:


Дэвсгэр зураг	1:500
Дагуу огтлол	хэвтээ 1:1000
	босоо 1:100
Хөндлөн огтлол	1:100
Уулзвар, огтлолцол	1:500
Бүтэц	1:20
- Авто зам, замын байгууламжийн ажлын зураг, тайлбар бичиг, инженер геологийн дүгнэлт, геодезийн ажлын тайлан, техникийн шаардлага, инженерийн шугам сүлжээний ажлын зураг, орчны тоймыг харуулсан 3D зураг, төслийн танилцуулга, бусад холбогдох бичиг баримтыг эх хувь 1ш, хуулбар хувь 3ш (хуулбар хувийг өнгөтөөр хувилж авчрах), тоон хэлбэрээр /DWG болон PDF/ хүлээлгэж өгнө
- Тухайн замын үндсэн элементүүдийг ( авто зам, зогсоол, хөдөлгөөн зохион байгуулалтын тэмдэг тэмдэглээ, инженерийн шугам сүлжээ гэх мэт) Layer тус бүрээр нь салгаж Autocad файлаар өгөх.
- ХБХГ-ын авто зам, замын байгууламж төлөвлөх даалгавар, НАЗХГ-ын авто замын зураг төсөл боловсруулах ажлын даалгаврын дагуу зураг төслийг боловсруулах.
- Төлөвлөлтийн шатанд буюу авто замын план зургийг ХБХГ, НАЗХГ, НГЗБА, НЗХТЗИГ, НТҮГ, ЗХУТ, ГУББГ ОНӨААТҮГ-тай тус тус зөвшилцсөний үндсэн дээр нарийвчилсан зураг төсөлд холбогдох газруудаас санал аван зураг төслийг баталгаажуулах.

**Хянасан:**

НАЗХГ-ын орлогч даргын албан үүргийг  
түр орлон гүйцэтгэгч


 /Д.Төрбилэг/

НАЗХГ-ын Бодлого зохицуулалтын хэлтсийн даргын  
албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

 /О.Энхбаатар/

**Боловсруулсан:**

НАЗХГ-ын Бодлого, зохицуулалтын хэлтсийн  
Усны барилга байгууламжийн мэргэжилтэн

 /Б.Ертис/

2020 оны...сарын...өдөр

НИЙСЛЭЛИЙН АВТО  
ЗАМЫН ХӨГЖЛИЙН ГАЗАР

Газрын байршил

Газрын зориулалт

Хан-Уул дүүрэг, 16-р хороо

Авто зам, замын байгууламж



Таних тэмдэг

Төлөвлөж буй авто зам, замын байгууламж

Төлөвлөж буй автомашины зогсоол

Хянасан:

НАЗХГ-ын Бодлого зохицуулалтын хэлтсийн даргын  
албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

...../О.Энхбаатар/

Боловсруулсан:

НАЗХГ-ын Бодлого зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн...../Б.Ертис/